

VI АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ШАЛГАЛТ

Хувилбар А

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:60 минут

Уучлах гэдэг ухааных

Долоо хоногийн эхний өдөр дунд сургуулийн нэгэн багш сурагчдаасаа “Амьдралын...” гэсэн тодотголтой нэгэн туршилтад орохыг хүссэн байна. нэр нь их сонирхолтой байсан тул хүүхдүүд дуртай нь аргагүй зөвшөөрчээ. Багш нь хүүхэд бүрийг 5 килограмм төмс, нэг ширхэг гялгар уут авчрах даалгавар өгсөнд тэд ихэд гайхсан ч маргааш нь бүгд авчирчээ. Багш ангидаа оронгуут асуусан харцаар өөдөөс нь ширтэх шавь нартаа хандан, “Хүүхдүүд ээ! Та нар өнөөдрийг хүртэл үзэн ядаж байсан, эсвэл дургүй хүмүүсийнхээ нэг нэг төмсөн дээр бичээд, тор луугаа хийгээд байгаарай” гэв. Хэдэн минутын дараа зарим хүүхдийн торонд ганц нэг төмс орсон байхад, заримынх нь бүр дүүрэн болсон харагдана. Сурагчдын торондоо төмсөө хийж дууссаны дараа багш “Одоо тортой төмсүүдээ долоо хоногийн турш хаа явсан газраа авч яв. Унтахдаа ч орныхоо хажууд тавиарай” гэлээ.

Товлосон долоо хоног нь дуусаж, багшийг ангидаа орж иртэл хүүхдүүд “Багш аа, ийм хүнд ачааг үргэлж авч явах хэцүү байна. Зарим төмс нь бүр ялзарч эхэллээ. Би залхаж байна. Бас ядарч байна” гэх зэргээр гомдоллож эхлэв.

Эцэс сүүлд нь багш инээмсэглэн байж, “Хүнийг уучлахгүй байх нь тэднийг бус, өөрийгөө шийтгэж байдаг” гэдгийг л та нарт ухааруулах гэсэн юм. Бусдын алдааг уучлахгүй бол бид сэтгэлдээ энэ төмс шиг хүнд ачааг тээж явдаг юм. Бусдыг уучилна гэдэг өөрөө өөртөө хийж байгаа сайн зүйл юм шүү дээ” гэж хэлжээ.

“Сургамжит өгүүллэг” зохиолын түүвэр, 2014

1. Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
 - A. Бусдад гомдсон тухай
 - B. Гомдлын тухай
 - C. Уурласан тухай
 - D. Бусдыг уучлах тухай
2. Эхийн төгсгөл хэсэгт багш сурагчдад юуг ойлгуулж, ухааруулах гэсэн бэ?
 - A. Бусдыг уучилна гэдэг өөрөө өөртөө хийж буй сайн зүйл гэдгийг
 - B. Бусдад гомдсон тухайгаа хэлэх нь өөрийгөө уучилж буй хэрэг гэдгийг
 - C. Гомдол гэдэг ялзарсан төмс шиг байдаг гэдгийг
 - D. Төмс сурагчдад хүнд ачаа болж байсан гэдгийг
3. Доор өгөгдсөн өгүүлбэрт байгаа тодруулсан үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг сонгоно уу.

Товлосон долоо хоног нь дуусаж, багшийг ангидаа орж иртэл хүүхдүүд “Багш аа, ийм хүнд ачааг үргэлж авч явах хэцүү байна. Зарим төмс нь бүр **ялзарч** эхэллээ. Би залхаж байна. Бас ядарч байна” гэх зэргээр гомдоллож эхлэв.

- A. Төмс хүнд ачаа болж байна гэсэн утгатай
 - B. Төмсний чанар муудаж байгааг илэрхийлсэн утгатай
 - C. Бүх төмс муудсан байсан гэсэн утгатай
 - D. Төмс сурагчдад гомдлыг илэрхийлсэн утгатай
4. Дараах өгүүлбэрийг ажиглаад цэгийн оронд тохирох баймж үг, бүтээврийг зөв сонгоорой.

..... уучлал гэдэг өөрөө өөртөө хийж байгаа сайн зүйл юм.

- A. Ер нь, -лгүй яахав дээ
 - B. Нээрээ, -х байлгүй дээ
 - C. Үнэндээ, -шүү дээ
 - D. Угаасаа, шив дээ
5. Дараах үгийг зөв бичгийн дүрмээр зөв тайлбарласан хэсгийг олоорой.
- Тос+л=Тосол
- A. Үйл үг дагаврын аргаар бүтсэн, үүсмэл үйл үг
 - B. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл бус үг
 - C. Үйлээс үйл үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг
 - D. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг
6. Зохиолч Д.Нацагдоржийн “Миний эжий” шүлгийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
- A. Сайхан ээжийн тухай
 - B. Эх хүний үр хүүхдээ хэрхэн өсгөж байгаа тухай
 - C. Зөөлөн цагаан гартай ээжийн тухай
 - D. Сургааль хэлдэг ээжийн тухай

7. Дараах өгүүлбэрийг зөв хөрвүүлэн бичсэн хэсгийг олоорой.

Хичээн зүтгэсэн хүний ажил бүтдэг
Хичээл зүтгэлтэй хүний ажил хэрэг бүтэх нь хурдан
Хичээл зүтгэснээр ажил бүтнэ
Хичээж зүтгэсний хэрэг бүтнэ

- A. Хичээн зүтгэсэн хүний ажил бүтдэг
- B. Хичээл зүтгэлтэй хүний ажил хэрэг бүтэх нь хурдан
- C. Хичээл зүтгэснээр ажил бүтнэ
- D. Хичээж зүтгэсний хэрэг бүтнэ

VI АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ШАЛГАЛТ

Хувилбар В

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:60 минут

Үндэс

Өвс ургамал, навч цэцэг ургавал хүн ба амьд амьтад даган баясдаг. Ургамал бол бүх амьд амьтны үндэс билээ. Иш нь дээшээ нахиалж, үндэс нь газарт ургадаг. Навч, гэрлийг чиглэн нарны туяаг шингээдэг бол үндэс нь хөрсөнд шигдэн газрын газрын шим тэжээлийг өөртөө шингээдэг. Навч, мөчир зэргийн ургаж байгаа нь нүдэнд харагддаг ч үндэс нь бидэнд харагддаггүй. Нүдэнд харагддаггүй энэхүү үндэс нь газрын гүнд тархаж бат бөх болбол илүү их үржил шимийг өгч чаддаг. Үндэс эрүүл байвал навч нахиалж, цэцэг дэлгэрч, жимс жимсгэнэ ургана. Навч нь үндсээр дамжин ирсэн шим тэжээлийг авч нарны туяаг шингээн хүнд шаардлагатай хүчилтөрөгчийг түгээн хүн амьтны гаргадаг нүүрстөрөгчийн хийг сордог. Үндэс газар сайн сууж гэмээн өндөр, сайхан ургана. Үндэс өчүүхэн, ядмагхан байвал мод, навч цэцэгс хатаж хорчийн цаашлаад үхдэг. Үндсийг сайтар бодож тунгаавал үндэс суурийн талаар бодогдох болно. Үндэсгүйгээр амьдрал ямар утга учиртай вэ? Нэгэн яруу найрагчийн хэлсэн шиг “Хавар модонд маш сайхан навчин хувцас өмсгөдөг, харин зун модонд цагаан, улаан, шар цэцэгсийг дэлгэрүүлж өгдөг, намар амтат жимс, жимсгэнэ өнгө өнгийн навчсыг өмсгөдөг бол хахир хүйтэн өвөл модонд амралт өгдөг”. Хүний амьдралд хавар, зун, намар, өвөл гэж байдаг. Хүүхэд нас бол миний амьдралын хаврын улирал юм.

Дон Боскогоос хүүхэд залуучуудад илгээсэн захидал, 2016

1. Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
 - A. Үндэс бол бүхий л амьд амьтан ургамлын үндэс суурь болох тухай
 - B. Дөрвөн улирал өөр өөрийн өнгөтэй тухай
 - C. Ургамал хэрхэн ургадаг тухай
 - D. Навч хэрхэн тэжээл авдаг тухай
2. Эхийн төгсгөл хэсэгт хаврын улирлыг хүний амьдралын ямар үетэй зүйрлэн дүрсэлсэн байна вэ?
 - A. Нялх бага нас
 - B. Хүүхэд нас
 - C. Идэр нас
 - D. Өтөл нас
3. Доор өгөгдсөн өгүүлбэрт байгаа тодруулсан үг ямар үүргээр орсон байгааг зөв тайлбарласан хэсгийг сонгоно уу.

Нэгэн яруу найрагчийн хэлсэн шиг “Хавар модонд маш сайхан навчин хувцас өмсгөдөг, харин зун модонд цагаан, улаан, шар цэцэгсийг дэлгэрүүлж өгдөг, намар амтат жимс, жимсгэнэ өнгө өнгийн навчсыг өмсгөдөг бол хахир хүйтэн өвөл модонд **амралт** өгдөг”.

- A. Өвлийн улирал маш хүйтэн байдаг гэсэн утгатай
 - B. Өвлийн улирал хахир хүйтэн байдаг тул навчны ургалт зогсож модод амардгийг илэрхийлсэн утгатай
 - C. Өвлийн улирал богино байдаг гэсэн утгатай
 - D. Өвлийн улирлыг бусад улиралтай харьцуулсан утгатай
4. Дараах өгүүлбэрийг ажиглаад цэгийн оронд тохирох баймж үг, бүтээврийг зөв сонгоорой.

.....хавар модонд маш сайхан навчин хувцас өмсгөдөг.....


- A. Ер нь, -лгүй яахав дээ
- B. Нээрээ, -х байлгүй дээ
- C. Үнэндээ, -шүү дээ
- D. Угаасаа, шив дээ

5. Дараах үгийг зөв бичгийн дүрмээр зөв тайлбарласан хэсгийг олоорой.

Бат+л=Батал

- A. Үйл үг дагаврын аргаар бүтсэн, үүсмэл үйл үг
 - B. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл бус үг
 - C. Үйлээс үйл үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг
 - D. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг
6. Зохиолч П.Бадарчийн “Есөн эрдэнийн орон” шүлгийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
- A. Сайн сайхан амьдрах тухай
 - B. Эх орон, уламжлалт өв соёлоо есөн эрдэнээр дүрслэн өгүүлсэн тухай
 - C. Элгэн садны тухай
 - D. Ээж, аавын тухай

7. Дараах өгүүлбэрийг зөв хөрвүүлэн бичсэн хэсгийг олоорой. /5 оноо/



- A. Галын дөлтэй ямагт өөд бадарна
- B. Галын дөл өөдөө бадар
- C. Галын дөл ямагт өөдөө бадарна
- D. Галын дөл өөдөө бадарна

VI АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ШАЛГАЛТ

Хувилбар С

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:60 минут

Цасан дээрх мөр

Хаврын наран мишээсэн цэнхэр тэнгэрийн доор цастай сүрлэг нуруу дүнхийнэ. Энэ бол Бурхан Буудай уулын хамгийн өндөр Үертийн эхний домогт бэрх даваа билээ. Үүгээр хоёр хөлтний мөр гарах нь төдий элбэггүй. Хариулах эзэнгүй мөртлөө араатан гөрөөс ч ховорхон явж, халих жигүүртэй атлаа шувуу ч цөөхөн нисэж, хашигдах боогдох юмгүйгээрээ салхи л чөлөөтэй зугаацдаг ийм л зэлүүд нутаг даа.

Гэтэл Үертийн эх рүү орох давааны мөөг шиг мөлгөр өвгөр ирмэгийн цасанд шигдсэн монгол гутлын мөр байдаг чинь юу билээ....Ойрхон ойрхон гишгэж, бүдэрч шургачсаар явсныг нь бодоход их л ядарч сульдсан шинжтэй. Мөрний хэмжээг харвал төдий л том хүн биш шиг. Ганц явган хүн өдий цагт өлсгөлөн араатны ам, өрөвдөх сэтгэлгүй цасан шуурганаас айхгүй ямар хэргээр яваа нь энэ вэ? Хаанахын хэн гэгч юм бол?

1. Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?
 - A. Үертийн давааны домгийн тухай
 - B. Үертийн бэрх даваанд гарсан цасан дээрх мөр хэний, ямар мөр болох тухай
 - C. Үертийн даваанд хүн амьдардаг эсэх тухай
 - D. Үертийн давааны үүсэл гарлын тухай
2. Эхийн эхлэл хэсгийн дүрслэл юуг илэрхийлсэн утгатай байна вэ?
 - A. Бурхан Буудай уулын хамгийн өндөр Үертийн эхний домогт бэрх даваа өндөр тухай
 - B. Бурхан Буудай уулын хамгийн өндөр Үертийн эхний домогт бэрх даваа хэр хол оршдог тухай
 - C. Бурхан Буудай уулын хамгийн өндөр Үертийн эхний домогт бэрх даваанд хүн амьдардаггүй зэлүүд газар байдаг тухай .
 - D. Бурхан Буудай уулын хамгийн өндөр Үертийн эхний домогт бэрх даваа орчмын цаг агаарын тухай
3. Доор өгөгдсөн өгүүлбэрт байгаа тодруулсан үг ямар үүргээр орсон байгааг зөв тайлбарласан хэсгийг сонгоно уу.

Хариулах эзэнгүй мөртлөө араатан гөрөөс ч ховорхон явж, халих жигүүртэй атлаа шувуу ч цөөхөн нисэж, хашигдах боогдох юмгүйгээрээ салхи л чөлөөтэй зугаацдаг ийм л **зэлүүд** нутаг даа.

- A. Ан гөрөөсгүй нутаг

- B. Эзгүй газар нутаг
 - C. Салхи ихтэй газар
 - D. Айл цөөтэй газар нутаг
4. Дараах өгүүлбэрийг ажиглаад цэгийн оронд тохирох баймж үг, бүтээврийг зөв сонгоорой.

.....ойрхон ойрхон гишгэж, бүдэрч шургачсаар явсныг нь бодоход их л ядарч сульдсан шинжтэй.....

- A. Ер нь, -лгүй яахав дээ
 - B. Нээрээ, -х байлгүй дээ
 - C. Мөн, -дэг
 - D. Угаасаа, шив дээ
5. Дараах үгийг зөв бичгийн дүрмээр зөв тайлбарласан хэсгийг олоорой.
- Ур+л=Урла
- A. Үйл үг дагаврын аргаар бүтсэн, үүсмэл үйл үг
 - B. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл бус үг
 - C. Үйлээс үйл үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг
 - D. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг
6. Зохиолч Ж.Дашдондогийн “Аранзал зээрд” шүлгийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
- A. Хурдан морь уралдах тухай
 - B. Морины явдлаар замын холыг туулж сургуульдаа ирж буй тухай
 - C. Замаар хурдан давхих тухай
 - D. Мориндоо ташуур өгөн хурд нэмэх тухай
7. Дараах өгүүлбэрийг зөв хөрвүүлэн бичсэн хэсгийг олоорой.

ᠲᠠᠷᠯᠠᠨ ᠦᠨᠡᠭ ᠲᠤᠭᠠᠯ ᠣᠨᠳᠤ ᠮᠡᠨᠳᠤ ᠣᠷᠯᠠᠭᠤ
ᠲᠠᠷᠯᠠᠨ ᠦᠨᠡᠭᠡᠨᠢ ᠲᠤᠭᠠᠯ ᠣᠨᠳᠤ ᠮᠡᠨᠳᠤ ᠣᠷᠠᠭᠤ

- A. Тарлан үнээ тугал онд мэнд орлоо
- B. Тарлан үнээний тугал онд мэнд оров
- C. Тарлан үнээг тугал онд оров
- D. Тарлан үнээний тугал оров

VI АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ШАЛГАЛТ

Хувилбар D

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:60 минут

Дугуй

Батбаатар дугуй унаж сурахыг туйлаас хүсэх болов. Нэг өдөр ахынхаа дугуйг унаж үзэхээр мордоод явах гэтэл дугуйтайгаа ойчжээ. Гараа шалбалсныг тоосон ч үгүй дугуйгаа босгоод дахиад явахдаа хураалттай байсан түлээ мөргөж унав. Хүчтэй мөргөснөөс толгой нь дүйрч байжээ. Ах нь гүйж ирээд: -Их өвдөв үү? Миний дүү, дугуй унаж сурах болоогүй байна. Хойтонгоос унаж сурах хэрэгтэй гэв.

Ахыгаа явсны дараа Батбаатар “Заавал дугуй унаж сурна даа” гэж хатуу шийджээ. Орой болоход Батбаатар дугуйн дээрээ тогтохоор барахгүй ойрхон газар явдаг болжээ. Айлын хүүхдүүд түүнд баяр хүргэв. Ээж нь ирээд:

-Миний хүү овоо доо гээд духан дээр нь үнсэв.

-Би дугуйнаасаа олон унасан гэж Батбаатарыг хэлэхэд

-Ямар ч бэрхшээлийг давж чадвал юуг ч сурдаг юм гэж ээж нь захив.

Д.Давааням, Цасны хүү тууж, 1984

1. Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?

- A. Ээжийн тухай
- B. Ахын тухай
- C. Батбаатар дугуй унаж сурсан тухай
- D. Батбаатар ээжийн захиасыг биелүүлсэн тухай

2. Эхийн эхлэл хэсгийн дүрслэл юуг илэрхийлсэн утгатай байна вэ?

- A. Батбаатар дугуй унаж сурах оролдлого хийж байгаа тухай
- B. Ахдаа зэмлүүлсэн тухай
- C. Ээж нь магтсан тухай
- D. Батбаатар дугуй унаж сурсан тухай

3. Доор өгөгдсөн өгүүлбэрт байгаа тодруулсан үг ямар үүргээр орсон байгааг зөв тайлбарласан хэсгийг сонгоно уу.

Миний дүү, дугуй унаж сурах болоогүй байна. **Хойтонгоос** унаж сурах хэрэгтэй гэв.

- A. Энэ жил
- B. Өнгөрсөн жил
- C. Ирэх жил
- D. Хоёр жилийн дараа

4. Дараах өгүүлбэрийг ажиглаад цэгийн оронд тохирох баймж үг, бүтээврийг зөв сонгоорой.

.....орой болоход Батбаатар дугуйн дээрээ тогтохоор барахгүй ойрхон газар явдаг болсон.....

- A. Ер нь, -лгүй яахав дээ
- B. Мөн, -шүү дээ
- C. Нээрээ, -х байлгүй дээ
- D. Угаасаа, шив дээ

5. Дараах үгийг зөв бичгийн дүрмээр зөв тайлбарласан хэсгийг олоорой.

Ногт+л=Ногтол

- A. Үйл үг дагаврын аргаар бүтсэн, үүсмэл үйл үг
- B. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл бус үг
- C. Үйлээс үйл үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг
- D. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг

6. Зохиолч С.Дуламын “Нүүдлийн цай” шүлгийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.

- A. Ээж цай чанаж буй тухай
- B. Холын гийчний тухай
- C. Нүүдлийг цайтай тосох ёс уламжлалын тухай
- D. Цай хэрхэн чанадаг тухай

7. Дараах өгүүлбэрийг зөв хөрвүүлэн бичсэн хэсгийг олоорой.

- A.Төрд хүн төлөв дөлгөөн тогтуун
- B.Төрийн хүний төлөв байдал дөлгөөн тогтуун
- C.Төрийг хүний төлөв байдал дөлгөөн тогтуун
- D.Төрийн хүний зан дөлгөөн тогтуун

ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

VI АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ШАЛГАЛТ

Хувилбар Е

Сурагчийн нэр.....

Анги.....

Хугацаа:60 минут

Болжмор

Би дүүгээ цэцэрлэгээс аваад харьж явлаа. Гэнэт өрөөсөн чих час хийв. “Хэн юм шидчихэв ээ” гэж гайхан ийш тийшээ харвал юу ч байсангүй. Чихээ гараараа дарж нэг нүдээ аньж нөгөө нүдээрээ дээшээ хартал модны мөчир дээр олон боргоцой харагдлаа. “Хүүе, өвөл яахаараа боргоцой байдаг билээ?” гээд сайн хартал мөчир дээр даарч бээрсэн болжморууд сууцгаана. Дүү:

-Энэ болжморууд хөлдөж үхэх нь ээ гэвэл ах нь:

-Хоёулаа үүр хийж өгье, өнөө орой л хийе гэв.

Аав бид хоёрт туслан үүр хийж, ээж будаа, талхны үртэс тавилаа. Маргааш орой дүүгээ авахдаа очиж харвал болжморууд баясгалантай шулганан, үүрнээсээ орж гарах нь ёстой шувууны найр болж байгаа бололтой. Бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг хараад, бид бас баяслаа.

Davalгаа.mn, 2016

1. Эхэд юуны тухай өгүүлсэн байна вэ?

A. Дүүгээ цэцэрлэгээс авсан тухай

B. Ах нь дүүгээ асарсан тухай

C. Даарсан болжморуудад үүр хийж өгсөн тухай

D. Гэр бүлийн тухай

2. Эхийн төгсгөл хэсэгт юуг илэрхийлсэн утгатай байна вэ?

A. Болжмор шувуунд үүр хийсэн тухай

B. Дүүгээ цэцэрлэгээс авч байгаа тухай

C. Болжмор шувуу шулганан жиргэхийг хараад баярласан тухай

D. Боргоцой ургасан тухай

3. Доор өгөгдсөн өгүүлбэрт байгаа тодруулсан үг ямар үүргээр орсон байгааг зөв тайлбарласан хэсгийг сонгоно уу.

“Хүүе, өвөл яахаараа боргоцой байдаг билээ?” гээд сайн хартал мөчир дээр даарч бээрсэн болжморууд сууцгаана.

A. Хөдөлгөөн ихтэй байх

B. Их даарснаас хөдөлгөөн нь удаашрах

C. Шулганан жиргэх

D. Дүүлэн нисэх

4. Дараах өгүүлбэрийг ажиглаад цэгийн оронд тохирох баймж үг, бүтээврийг зөв сонгоорой.

..... бидний хажуугаар дээгүүр доогуур хөөрхөн болжморууд нисэн жиргэхийг харсан

- A. Ер нь, -лгүй яахав дээ
- B. Мөн, -шүү дээ
- C. Нээрээ, -х байлгүй дээ
- D. Угаасаа, шив дээ

5. Дараах үгийг зөв бичгийн дүрмээр зөв тайлбарласан хэсгийг олоорой.

Тоо+л=Тоол

- A. Үйл үг дагаврын аргаар бүтсэн, үүсмэл үйл үг
- B. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл бус үг
- C. Үйлээс үйл үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг
- D. Нэрээс нэр үг бүтээх аргаар бүтсэн, үүсмэл үг

6. Зохиолч З.Түмэнжаргалын “Монголын тал нутаг” шүлгийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.

- A. Энэрэл хайрын тухай
- B. Газар шороо үнэ цэнэтэй тухай
- C. Нөхөрлөлийн тухай
- D. Монголын тал нутгийн тухай

7. Дараах өгүүлбэрийг зөв хөрвүүлэн бичсэн хэсгийг олоорой.

A.Төл малаа торниулаад маллах

B.Төл малаа торнулан маллана

C.Төл малаа торниулан маллая

D.Төл мал торниулан маллая

ᠲᠥᠯ ᠮᠠᠯᠠᠭ ᠲᠣᠷᠨᠢᠭᠤᠯᠠᠭ ᠮᠠᠯᠤᠯᠠᠬᠤ
ᠲᠥᠯ ᠮᠠᠯᠠᠭ ᠲᠣᠷᠨᠢᠭᠤᠯᠠᠭ ᠮᠠᠯᠤᠯᠠᠨᠠ
ᠲᠥᠯ ᠮᠠᠯᠠᠭ ᠲᠣᠷᠨᠢᠭᠤᠯᠠᠭ ᠮᠠᠯᠤᠯᠠᠶ᠋ᠠ

VI АНГИЙН АНГИ ДЭВШИХ МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ШАЛГАЛТЫН ЗӨВ ХАРИУЛТ

Даалгавар	A хувилбар	B хувилбар	C хувилбар	D хувилбар	E хувилбар
1	D	A	B	C	C
2	A	B	C	A	C
3	B	B	B	C	B
4	C	C	C	B	B
5	A	A	A	A	A
6	B	B	B	C	D
7	B	C	B	B	C